



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/69

Өвт

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, 46 дугаар зүйлийн 46.1.4, 46.1.6 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын төвийн нутаг дэвсгэр дэх хуучин хогийн цэг орчмын цэвэрлэгээ, хог зайлуулалт хийх ажлыг шууд гэрээ байгуулах аргаар 4 дүгээр багийн иргэн Ч.Эрдэнэбаатараар гүйцэтгүүлсүгэй.

2. Ч.Эрдэнэбаатартай гэрээ байгуулж хэрэгжилтийн явцад хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

3. Сумын төвийн нутаг дэвсгэр дэх хуучин хогийн цэг орчмын цэвэрлэгээ, хог зайлуулалт хийх ажилд шаардагдах 7990000 (Долоон сая есөн зуун ерэн мянган) төгрөгийг гэрээнд заасны дагуу Орон нутгийн хөгжлийн сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн албаны нягтлан бодогч (Б.Мажигдэлгэр)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

М.ЖАМБЯНШАРАВ



D:My Doc A-4 zahiramj /Zasag darga/

051010157